



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/575

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1."Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд Чандмань, Эрдэнэ, Бигэр, Цогт, Тайшир, Гуулин, Дэлгэр, Бугат, Халиун, Алтай, Цээл, Төгрөг, Дарви, Шарга сум, Рашаант багт бүсчлэн зохион байгуулах явуулын тусламж үйлчилгээ, үзлэг, оношилгоо, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээнд зарцуулах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 98,137,000 (ерэн найман сая нэг зуун гучин долоон мянган) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд батлагдсан эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

